ХУВААЛЦСАН ЮМ.”

Удмаа таньж хул болдог
Усаа таньж мал болдог





“ДЭМ ДЭМЭНДЭЭ ТӨСӨЛ” (In-Their Shoes)

Нөлөөлөл

Хандивлагчид: Долоо дахь Өдрийн Адвентист Сүмийн Ерөнхий Чуулганы Дэлхийн сүмийн Ерөнхийлөгч, АДРА Монгол ОУБ-ын хамт олон, хувь хандивлагчид

Нийт төсөв: 10,000 ам.доллар

Үргэлжлэх хугацаа: Жил бүр 1 удаа

Зорилтот газар: Улаанбаатар хотын Налайх дүүрэг

Үр шим хүртэгчид: 100 гэр бүл, 50 хүүхэд

ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Дэм дэмэндээ” төслийг бид 2021 оноос хойш Улаанбаатар хотын гэр хорооллын тусламж нэн шаардлагатай иргэдэд туслах зорилгоор байгууллагын ажилчдын сэтгэл, нөөц боломжид тулгуурлан эхлүүлсэн байдаг. Жил бүр Улаанбаатар хотын нэг дүүрэгт амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой 100 өрх, сургуулийн насны 50 хүүхдийг дэмжин ажиллаж байна. Бид дүүргийн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын газар, хороод, бусад төрийн байгууллагуудтай хамтран тусламж үзүүлэх өрхөө сонгодог.

Төсөл хэрэгжүүлэх болсон шалтгаан

Монголын ихэнх эмзэг бүлгийн өрхүүд, тэр дундаа орлого багатай өрхүүдийн амьжиргааны түвшин доройтоход 2020 оны цар тахал илтэд нөлөөлсөн. Эдгээр эмзэг бүлгийн өрхүүдэд уг хүндрэлийг даван туулахад дэм болох үүднээс сайн дурын үндсэн дээр АДРА Монгол ОУБ-ын ажилтнууд өөрсдийн санхүүгийн бэрхшээлийг үл харгалзан сар бүрийн цалингаасаа мөн хувь хандивлагчид хандив өргөн Улаанбаатар хотын иргэдэд туслах санаачилга гаргасан. Улмаар “Дэм дэмэндээ” төслийг 2021 оноос хойш бид хэрэгжүүлж байна.



ОНЦЛОХ АЖЛУУД

Нийслэл Улаанбаатар хотоос баруун зүгт 1800 км-ийн зайд орших Баян-Өлгий, Завхан аймагт энэхүү зудын хариу арга хэмжээ авах төслийг хэрэгжүүлээ.

Хариу арга хэмжээ үзүүлэхэд чиглэсэн түншлэл

АДРА Монгол, Долоо дахь өдрийн Адвентист чуулган, АДРА Ази болон АДРА Интернэйшнэл хамтран уг төслийг санхүүжүүлэв.

Төслийг хэрэгжүүлэхэд чиглэсэн хамтын ажиллагаа

Зорилтот сумдын Засаг дарга нар тус байгууллагын аргачлалын дагуу тусламжид хамрагдах өрх сонгохдоо төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн төлөөлөөс бүрдсэн хамтарсан ажлын хэсэг байгуулсан. Өрх сонгох заавар, удирдамжаар ажлын хэсгийг төслийн зүгээс хангаж ажиллав.

150 өрх сонгогдсоны дараа төслийн багийнхан тэдгээр өрхүүдтэй утсаар холбогдож, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх

тухай танилцуулж, өрх бүрийн үндсэн болон дансны мэдээллийг баталгаажуулсан.

Мөнгөн тусламжийн арга хэмжээ

2023 оны 02 дугаар сарын 03-ны өдөр малчдын дансанд мөнгөн шилжүүлэг хийсэн бөгөөд санхүүгийн баг хүн бүрийн дансны мэдээллийг шалгаж ажилласан тул тусламжийн ажиллагааг хэрэгжүүлэхэд ямар нэгэн бэрхшээл гараагүй. Баян-Өлгий аймгийн хоёр сумын хамгийн эмзэг бүлгийн 100, Завхан аймгийн нэг сумын 50 өрх тус бүрд 300,000 төгрөг буюу (82 доллар) шилжүүлсэн.

Малчдын дийлэнх нь тусламжийн мөнгийг (85%) малын өвс тэжээл авахад зориулсан бол үлдсэн хэсэг нь (15%) нь гурил, будаа зэрэг өрхийн хэрэгцээний хүнсний бүтээгдэхүүнд зарцуулсан байна.

Аймаг болон сумдын удирдлагууд уг төслийг хэрэгжүүлэх бүх шатанд бидэнтэй амжилттай хамтран ажилласан юм.





ЗУДЫН ЯАРАЛТАЙ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ ТӨСӨЛ (DEMBUZ)

Нөлөөлөл

Төслийн санхүүжүүлэгч: АДРА Интернэйшнэл, АДРА Ази болон Адвентист чуулган

Нийт төсөв: 15000\$

Төслийн үргэлжлэх хугацаа: Нэг удаагийн буцалтгүй тусламж (2023.01.10-2023.02.20)

Төслийн хэрэгжиж буй газар: Завхан аймгийн Идэр болон Баян-Өлгий аймгийн Бугат, Сагсай сумд

Үр шим хүртэгчид: Орон нутгийн 150 малчин өрх

Төслийн арга барил: Нэг удаагийн буцалтгүй мөнгөн тусламж олгох

Хамтрагч байгууллага: АДРА Монгол, АДРА Ази, Онцгой байдлын Ерөнхий Газар, Аймгуудын Онцгой байдлын газрууд, Завхан болон Баян-Өлгий аймгуудын ЗДТГ, ОУБ-ууд

ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2023 оны 2-р сарын 1-ний байдлаар Монгол Улсын нутаг дэвсгэрийн 70 орчим хувь буюу нийт 22 аймгийн 310 сумдын нутаг зудын өндөр эрсдэлд өртсөн. Энэ нь 191,000 малчин өрхийн амьжиргаанд шууд нөлөөлсөн ба эдгээр малчин өрхийн 87,000 орчим нь 200-аас доош толгой малтай эмзэг бүлгийн өрхүүд байв. Мөн 2-р сарын эхээр нийт 416,560 орчим мал хорогдсон. АДРА Монгол ОУБ нь НҮБ-ын Хүмүүнлэгийн байгууллагуудтай харилцан уялдаатай ажилладаг ба олон улсын байгууллагуудын гаргасан шалгуур үзүүлэлтүүдийн дагуу гамшигт нэрвэгдсэн тусламж нэн шаардлагатай 150 малчин өрхөд мөнгөн тусламж хэлбэрээр яаралтай тусламж үзүүлэв.



24



ОНЦЛОХ АЖЛУУД

Хөлдөөсөн үрийн зохиомол хээлтүүлэг, үр хөврөл шилжүүлэн суулгах ажлын хүрээнд

2023 оны 9-р сарын сүүлээр Австралийн Генетик Үүлдрийн Төвд (Central West Genetics) мэргэжлийн малын эмч нарын хяналтад 230 тун үр болон 148 хөврөлийг цуглуулж, боловсруулж, хадгалж, Австрали Улсаас Монгол Улс руу амжилттай импортлов.

2023 оны 10 дугаар сарын 16-20-ны өдрүүдэд Малын Удмын Сангийн Үндэсний Төвийн лабораторид Хангай, Орхон үүлдрийн 352 тээгч хонинд Австралийн Генетикийн төвийн туршлагатай малын эмч нар гүн хөлдөөсөн үр болон хөврөлөөр зохиомол хээлтүүлэг хийх, үр хөврөл шилжүүлэн суулгах сургалтыг Малын Удмын Сангийн болон Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн нийт 9 малын эмч болон бусад мэргэжилтнүүдийг оролцуулан амжилттай зохион байгууллаа.

Нарийн ноосны өртгийн сүлжээ

2023 оны 10-р сарын 5-6-ны өдрүүдэд төслийн баг ноосны чанарыг сайжруулснаар Хангай болон Орхон хонины малчдын орлогод хэрхэн нөлөөлөх, ноосны үнэ цэнийг нэмэгдүүлэх боломжийг тодорхойлох зорилгоор Сэлэнгэ аймгийн Цагааннуур, Орхон сумдын орон нутгийн удирдлагууд болон Хангай,

Орхон үүлдрийн хоньчидтой уулзалт хийв.

2022 оны 10 дугаар сард 308 тээгч эм хонинд дурангийн аргаар зохиомол хээлтүүлэг хийснээс 195 буюу 65 хувь нь хээлтсэн. Үүнээс 2023 оны тавдугаар сард 134 хурга төрсөн ч 38 нь л амьд бойжиж байна. Хурганы хорогдлын гол шалтгаан нь хээлтэй хонины хээлтэй үеийн тэжээлийн хомсдол, өвлийн хүйтэн өдрүүд болон зудын байдал эрс нөлөөлсөн гэж дүгнэсэн. Иймд хонь, хурга хорогдохоос урьдчилан сэргийлэх зорилгоор 360 эм хонинд илчлэг өндөртэй хивэг, тэжээллэг өвс, эрдэс бодис худалдан авах, санхүүгийн дэмжлэг үзүүлэх ажлыг 2023 оны 9 дүгээр сард зохион байгууллаа.

Удамшлын өндөр холбогдолтой үр, хөврөл тодорхойлох хүрээнд

2023 оны 6 болон 10-р сард хонины хээлтэй болон хөхүүл үеийн талаарх мэдээлэл, шинээр төрсөн хурганы талаарх шаардлагатай мэдээллийг цуглуулж Австралийн генетикийн мэдээллийн санд оруулсан. Энэхүү мэдээллийн сан нь манай үүлдрийн хувьд анхдагч бөгөөд Монгол судлаачид онлайнаар нэвтэрч, үр болон хөврөлөөр төрүүлсэн удамшлын өндөр ач холбогдолтой малыг тодорхойлоход ашиглах боломжтой.





НАРИЙН БОЛОН НАРИЙВТАР НООСТ ХОНИНЫ ҮҮЛДЭР УГСААГ САЙЖРУУЛАХ ТУРШИЛТЫН ТӨСӨЛ (FINE WOOL)

Эдийн засгийн хөгжил/амьжиргаа

Санхүүжүүлэгчид: АДРА Интернэйшнэл, Хелп Интернэйшнэл, АДРА Ази, АДРА Австрали, АДРА Япон, АДРА Хонг Конг/Хувийн хандивлагч, Монгол дахь Австралийн Элчин Сайдын Яам

Нийт төсөв: 255,962 ам.доллар

Үргэлжлэх хугацаа: 2022 оны 7-р сарын 1-нээс 2024 оны 6-р сарын 30 хүртэл (24 сар)

Зорилтот газар: Сэлэнгэ аймгийн Цагааннуур болон Орхон сум

Хамтрагч байгууллагууд: ХХААХҮЯамны харьяа Малын Удмын Сан, ХААИС-ийн харьяа Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн, Сэлэнгэ аймгийн ЗДТГ

ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улс 1990-ээд оны үед 3-4 төрлийн нарийн ноост үүлдрийн 500,000 гаруй тоо толгой хоньтой, нарийн ноосны дотоодын хэрэгцээг 100% хангаж байсан боловч сүүлийн 30 жилийн хугацаанд үүлдэр угсааг сайжруулах, тоо толгойг нэмэгдүүлэхэд чиглэсэн системтэй арга хэмжээ аваагүйн улмаас нарийн ноост хонины тоо толгой ердөө 13,000 орчим болж буурсан. Австрали Улсын Мерино, Дохне Мерино удамшлын өндөр ач холбогдолтой 5000 тун гүн хөлдөөсөн үр болон хөврөлийг Хангай болон Орхон үүлдрийн нарийн ноост эм хонинд хөлдөөсөн үрийн зохиомол хээлтүүлэг, үр хөврөл шилжүүлэн суулгах аргаар хонины ноосны чанар, тоо толгойг нэмэгдүүлэхийг зорин ажиллаж байна. Улмаар ноосны чанар, тоо хэмжээг нэмэгдүүлэх замаар малчдын амьжиргааг дэмжих хэтийн зорилготой.



ОНЦЛОХ АЖЛУУД

Төслийн нээлт

“NextGen Celebrations! Mongolia” халдварт бус өвчнөөс сэргийлэх төслийн нээлтийг 2023 оны 7-р сарын 17-нд зохион байгууллаа. Нээлтийн үйл ажиллагаанд АДРА Интернэйшнэлийн Хөтөлбөр, инновац хариуцсан захирал Соняа Фуна, Эрүүл мэндийн хэлтсийн дарга Хосуэ Ореллана, Эрүүл мэндийн ахлах зөвлөх Шарон Тобинг, АДРА Монгол ОУБ-ын Суурин төлөөлөгч Винделл Маранан, ЭМЯ, Монголын Адвентист Чуулганы төлөөлөгчид, сурагчид мөн холбогдох бусад байгууллагуудын төлөөлөл оролцлоо. Төслийн нээлтийн үйл ажиллагааны дараа сургуулийн захирлууд, техникийн мэргэжилтнүүд, АДРА Монгол ОУБ болон төслийн багийнхны дунд төслийг хэрэгжүүлэхэд нэгдсэн ойлголт, үр дүнтэй хамтын ажиллагааг бий болгох, аргачлалыг танилцуулах, төслийг хэрэгжүүлэх санал санаачилга, цаашдын төлөвлөгөөг хамтран тодорхойлоход чиглэсэн 2 өдрийн семинарыг зохион байгуулсан.

Түншлэгч 4 сургуультай хамтын ажиллагааны санамж бичиг зурах үйл ажиллагаа

8-р сарын 17, 9-р сарын 20-нд Тусгал дунд сургууль, Эрдмийн оргил улсын сургууль, “Хөгжил” цогцолбор сургууль, 84-р дунд сургуультай хамтран ажиллах, төслийг хамтран хэрэгжүүлэх санамж бичиг байгуулсан.

Хамтын ажиллагаа

Долоо дахь Өдрийн Адвентист Чуулганы Эрүүл Мэндийн Хэлтэс, зорилтот дүүргүүдийн Эрүүл Мэндийн Газар, АМОС ТББ, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Боловсролын ерөнхий газар, Монгол Хоол тэжээлийг сайжруулах төв болон АНУ-ын Калифорни дахь Лома Линда их сургуулийн Нийгмийн эрүүл мэндийн сургууль зэрэг байгууллагатай хамтран ажиллаж байна.

Мэдээлэл сурталчилгаа, сургалтын материал

ХБӨ-нөөс урьдчилан сэргийлэх, амьдрах ухаанд суурилсан мэдлэг өсвөр үеийнхэнд

олгох зорилготой 32 сэдвийг хамарсан дөрвөн бүлгээс бүрдсэн 28 хуудас гарын авлагыг амжилттай боловсруулсан. Төслийн баг хоёр сургуульд мэдээлэл, сургалт сурталчилгааны (IEC) материалын төрөл, хүлээн авах сувгийн талаар хэрэгцээний үнэлгээ хийсэн.

Ээлтэй орчин бүрдүүлэх чиглэлээр

Тусгал дунд сургууль, Эрдмийн оргил улсын сургуулийн эрүүл мэндийн өрөөг засварлан тохижуулж шаардлагатай тавилга тоног төхөөрөмжийн худалдан авалтыг гүйцэтгэв.

Төслийн хэрэгжилтийн судалгааны ёс зүйн зөвшөөрөл

Эрүүл мэндийн яамны Анагаах ухааны ёс зүйн хяналтын хорооноос судалгаа хийх ёс зүйн зөвшөөрлийг албан ёсоор авснаар “Улаанбаатар хотын 12-15 настай өсвөр үеийнхэнд эрүүл зан үйлд суралцахад ээлтэй орчин бүрдүүлэх нь” судалгааг АДРА Монгол, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Лома Линдагийн Их Сургууль хамтран хэрэгжүүлэхээр болсон. Уг судалгааг 2024 оны эхээр хийхээр төлөвлөж байна.

Суурь судалгаа, саад бэрхшээлийн судалгаанд зориулж мэдээлэл цуглуулах

20 судлаачаас бүрдсэн мэдээлэл цуглуулах баг “Мэдлэг, Хандлага, Чадавх” -ийн судалгаанд 655 эцэг эх, 655 сурагчаас ярилцлага авч байна.

ADRA

Alpha Mongols

NextGen CELEBRATIONS! Mongolia

NEWSLETTER ISSUE | OCTOBER 2023

WHAT'S INSIDE!

- What is NextGen CELEBRATIONS! Mongolia
- Message from Leadership
- Overall Project Goal
- Expected Outcomes
- Sustainability
- Project Highlights
- Meet Our Team

What is NextGen CELEBRATIONS! Mongolia?

The NextGen CELEBRATIONS! Mongolia NCD Project is a dynamic three-year initiative that stands as a country-specific pilot of ADRA International's global non-communicable diseases (NCD) approach. CELEBRATIONS! is an acronym encompassing 12 healthful living principles: (C) - choices, (E) - exercise, (L) - liquid, (E) - environment, (B) - belief, (R) - rest, (A) - air, (T) - temperance, (I) - integrity, (O) - optimism, (N) - nutrition and (S) - social support and services. This project will focus on adolescents (12-15 year-olds) on six of the twelve components: choices, exercise, temperance, optimism, nutrition, and social support. These pillars form the foundation of our holistic approach to preventing NCDs among Mongolia's youth. Our mission is clear: to empower Mongolian adolescents aged 12-15 with the knowledge and tools to lead healthy lives, preventing non-communicable diseases (NCDs) in their communities. As we embark on this transformative journey, join us in creating a healthier future for Mongolia.



ХАЛДВАРТ БУС ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТӨСӨЛ (NCD)

Эрүүл мэнд / Шим тэжээл

Санхүүжүүлэгч: Долоо дахь Өдрийн Адвентист Сүмийн Ерөнхий Чуулган, АДРА Интернэйшнэл, АДРА Хонг Конг, АДРА Австри

Нийт төсөв: 510,000 ам.доллар

Үргэлжлэх хугацаа: 2023 оны 6-р сарын 01-нээс 2026 оны 5-р сарын 31

Зорилтот бүс нутаг: Улаанбаатар хотын Чингэлтэй, Сонгинохайрхан, Баянзүрх, Налайх дүүргүүд

Зорилтот бүлэг: 2000 өсвөр үеийнхэн

Түншлэгч байгууллагууд: Чингэлтэй дүүргийн Тусгал, Сонгинохайрхан дүүргийн “Хөгжил” цогцолбор, Баянзүрх дүүргийн Ерөнхий боловсролын 84 дүгээр сургууль, Налайх дүүргийн “Эрдмийн-Оргил” цогцолбор сургууль, Сэтгэцийн Эрүүл Мэндийн Үндэсний Төв, Эрүүл мэндийн яам, АНУ-ын Лома Линда Их Сургуулийн Нийгмийн эрүүл мэндийн сургууль, Боловсролын Ерөнхий газар, БШУЯ

ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Энэхүү төсөл нь АДРА Интернэйшнэл ОУБ -аас баримталдаг халдварт бус өвчинтэй (ХБӨ) тэмцэхэд чиглэсэн хандлага, аргачлалыг манай улсын онцлогтой уялдуулан хэрэгжүүлэх зорилготой туршилтын төсөл юм. CELEBRATIONS буюу эрүүл амьдралын 12 зарчмыг илэрхийлсэн товчлолоос манай улсын өсвөр үеийнхний дунд илүү хэрэгцээтэй байгаа нь тогтоогдсон Зөв сонголт, Дасгал хөдөлгөөн, Зориг тэвчээр, Өөдрөг үзэл, Хоол тэжээл, Нийгмийн дэмжлэг гэсэн зургаан эрүүл амьдралын зарчмын хүрээнд бид үйл ажиллагаагаа чиглүүлнэ. Бидний эрхэм зорилго бол 12-15 насны Монголын өсвөр үеийнхэнд эрүүл аж төрөх мэдлэг, хандлага, дадлыг төлөвшүүлснээр ХБӨ-ний эрсдэлт хүчин зүйлээс урьдчилан сэргийлэхэд оршино.

Төслийн хүрээнд өсвөр үеийнхэн, тэдэнтэй хамгийн их харилцдаг гэр бүлийн гишүүд болон сургуулийн орчин дахь хүмүүс эрүүл, эерэг зан үйл, дадлыг нэвтрүүлж, өдөр тутамдаа хэрэгжүүлэх үр чадвар эзэмшсэнээр халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйл буурна гэж төлөвлөж байна. Зан үйл өөрчлөх аргачлал, хүн төвтэй загварын дагуу бид олон нийт, хүүхдүүд, эцэг эх, холбогдох төрийн байгууллагууд, сургуулийн удирдлагууд, бизнес эрхлэгчид, салбарын мэргэжилтнүүд зэрэг нийт талуудыг хамруулан, тэдний санал, санаачилга оролцоонд үндэслэн эрүүл амьдралын давлагаа, соёлыг бий болгох бодлого, үйл ажиллагааг хамтран боловсруулж хэрэгжүүлснээр тогтвортой үр дүн, нөлөөнд хүрэхийг зорьж байна.



ОНЦЛОХ АЖЛУУД

Бэлчээрийн цогц менежментийн аргачлалыг ашиглаж эхэлснээр Идэр сумын малчдын хандлага өөрчлөгдөж байна. 2022 оны сүүлээр хашсан бэлчээрийн 4 туршилтын талбайд бэлчээрийн өвс, ургамал ургасны дараа тодорхой хугацаанд мал бэлчээрлүүлэн хөрсийг малын хөлөөр сийрэгжүүлэн аргал, хорголоор нь бордож туршсан ба 2023 онд бэлчээрийн ургамал илтэд сайжирсан үр дүнд хүрсэн. Уг туршилтын талбай нь бэлчээрийн цогц менежментийн аргачлалын дагуу бэлчээрийг төлөвлөгөөтэй ашигласнаар бэлчээр хэрхэн сэргэж болдгийг малчдад илүү бодитоор харуулах ач холбогдолтой байсан. 2023 оны 8 сард туршилтын талбай доторх бэлчээрийн ургамлыг гаднахтай харьцуулахад 30 см-ээр илүү өндөр ургаж мэдэгдэхүйц өөрчлөлт ажиглагдсан ба төслийн үйл ажиллагааны талаарх малчдын санал, сэтгэгдэл бидэнд ч урам зориг өгсөн.

2023 оны 3, 11-р сард АНУ-ын Колорадо мужид төвтэй Сэйвори институттэй хамтран нийт 46 хүний бүрэлдэхүүнтэй 2 удаагийн онлайн сургалт, мөн 5-р сард “Зуны Бэлчээрийн төлөвлөлт”-ийн талбайн сургалтыг 47 малчдыг хамруулан амжилттай зохион байгуулсан. Эдгээр сургалтаар бэлчээрийн нөхөн сэргэх хугацааг тодорхойлох, зуны бэлчээрийн төлөвлөгөөг боловсруулах, 2024 он хүртэл бэлчээрийн ургамал ургалтын улирал хүртэл өвөлжөөний бэлчээр болон туршилтын талбайг хэрхэн ашиглах талаар ярилцсан. Мөн зуны бэлчээрийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлсэн малчид өөрсдийн туршлагаасаа хуваалцлаа.

Загвар байдлаар хашсан 4 туршилтын талбайн бэлчээрийг түр амраах, ургамал ургах хугацааг тодорхойлох ач холбогдлыг харуулах зорилгоор тогтмол мониторинг хийсэн. Мөн 7 бэлчээрийн газраас 8 хөрсний дээжийг ХААИС-ийн мэргэжлийн багш авч, шинжлүүлэн хамтарч ажилласан.

Малчин эмэгтэйчүүдийг чадавхжуулах, орлогын эх үүсвэрийг төрөлжүүлэх хүрээнд

Малчин эмэгтэйчүүдийн сүү, цагаан идээ боловсруулах мэдлэг, чадавхыг бэхжүүлэх зорилгоор 2023 оны 6 сард Сүү цагаан идээ боловсруулах технологийн сургалтыг зохион байгуулсан. Энэхүү сургалтаар 31 малчин эмэгтэйд стандартын шаардлага хангасан төрөл бүрийн сүү, сүүн бүтээгдэхүүнийг технологийн горимын дагуу боловсруулах, нэмүү өртөг шингээсэн олон нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх талаарх онолын болон практик мэдлэг олгосон. Сүүний жижиг тоног төхөөрөмжийг сургалтад тогтмол оролцдог 22 малчин эмэгтэйд олгосон.

Бэлчээрийн цогц менежментийн аргачлалыг олон нийтэд таниулах, сурталчлах хүрээнд

“Төлчин эмэгтэйчүүдийн чуулга уулзалт” 2023 оны 05 сард Идэр суманд 158 малчин эмэгтэйчүүдийг хамруулан зохион байгуулагдсан. Бэлчээрийн цогц менежментийн аргачлалын талаарх мэдээллийг орон нутгийн байгууллага, төслийн багийн зүгээс уулзалтын үеэр оролцогчдод хүргэв. 5 болон 10-р сард зохион байгуулагдсан Идэр сумын 4 удаагийн Багийн Иргэдийн Нийтийн Хуралд төслийн баг оролцож төслийн үйл ажиллагаа болон бэлчээрийн цогц менежментийн аргачлалын талаар нийт 414 малчдад танилцуулж ажиллав.

Мөн Багийн Иргэдийн Нийтийн хурлын үеэр бэлчээрийн цогц менежментийн аргачлалын талаар 3 төрлийн брошюрыг боловсруулж тус бүрээс 200 ширхгийг хэвлэн малчдад тараасан.



Миний түүх

БОЛОРЦЭЦЭГ,
САРЛАГИЙН СҮҮНИЙ ЭМЭГТЭЙ

Завхан аймгийн Идэр сумын Дархан-Уул багийн малчин Ш.Болорцэцэг

Ш.Болорцэцэг нь Завхан аймгийн Тосонцэнгэл суманд ажиллаж амьдарч байсан ба төв суурин газар эрхэлсэн тодорхой ажилгүй, тогтвортой орлогын эх үүсвэр байхгүй, эсрэгээрээ зарлага ихтэй нөхцөл байдлаа шийдэх зорилгоор гэр бүлийн хүнтэйгээ ярилцан 2016 оноос хойш тус аймгийн Идэр сумын Дархан-Уул багт малчин болсон.

Үхэр голдуу малтай учир зун, намар үнээгээ саан, саалиа боловсруулан эцсийн бүтээгдэхүүн болгон худалдан борлуулж эрхийнхөө хэрэгцээг ханган сайхан амьдарч байна.

2021 оноос “Бэлчээрийн цогц менежмент” төслийн сургалт, уулзалтад тогтмол хамрагдан зуны бэлчээрийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж эхэлсэн нь үр дүнгээ өгч байгаад их урам орсон хэмээн тэрээр баяртай ярих. Төслийн сургалтаас олон шинэ зүйлийг мэдэж авсан ба зарим малчдын хувьд ган, зуд зэрэг цаг агаарын байдал, мөн өөрсдийнх нь сэтгэлгүй байдлаас шалтгаалан бэлчээрээ сайжруулах талаар үр дүн гаргаж чадахгүй байгаад харамсаж байгаага мөн илэрхийллээ.

Болорцэцэгийн хувьд айл саахалтынхантайгаа сүүлийн хоёр жилийн хугацаанд зуны бэлчээрийн төлөвлөгөө боловсруулан хамтран ажиллаад эхний үр дүнгээ өөрсдөө харсан билээ. Тэрээр хэлэхдээ “Зуны бэлчээрээ бид 5 хэсэгт хуваагаад хэсэгчилсэн бэлчээр бүрдээ 7 хоног бүх малаа хариулсан. Нөөцөд байгаа бусад 4 газрын бэлчээрийн ургамал энэ хугацаанд (долоо хоног тутам) 3-4 см-ээр нэмэгдэж байгааг бид ажигласан. Иймд малчид бид өөрсдөө хичээх хэрэгтэй байна.

Бэлчээрээ сэлгээтэй ашигласнаар хүний нүдэнд харагдаж, гарт баригдахуйц үр дүн гарч, бэлчээр сэргэн, мал тогтвортой бэлчээрлэн энэ зуны хувьд 7 сарын 20-ны үед тарга аваагүй байсан мал 08 сарын 05 гэхэд тарга хүчээ авсан нь мал маллаж байгаа бидэнд сайхан байлаа.

Тиймээс “Бэлчээр ямар байх нь малчид хэрхэн малаа зөв зохистой хариулахаас ихээхэн шалтгаалдаг юм байна. Идэр сумын малчдадаа малаа хот айлаараа хамтдаа хуваарьтай маллаж, бэлчээрийн доройтлоос хамтдаа гарцгаая хэмээн уриалж байна” гэлээ.



БЭЛЧЭЭРИЙН ЦОГЦ МЕНЕЖМЕНТ ТӨСӨЛ (PLUS)

Хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуй

Төслийн санхүүжүүлэгч: АДРА Швейцар, Швейцарын Цурих болон Ааргау аймгууд

Нийт төсөв: 292,933 Швейцар франк

Төслийн үргэлжлэх хугацаа: 2021 оны 6 сарын 1-нээс 2024 оны 5 сарын 31

Төсөл хэрэгжиж буй газар: Завхан аймгийн Идэр сум

Үр шим хүртэгчид: Орон нутгийн 100 малчин өрх

Төслийн аргачлал: Бэлчээрийн цогц менежментийн аргачлал

Хамтрагч байгууллагууд: АДРА Швейцар, АДРА Ази, АНУ-ын Сэйвори Институт, Завхан аймгийн ЗДТГ, Идэр сумын ЗДТГ, Хөдөө аж ахуйн их сургууль

ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Бэлчээрийн цогц менежмент төсөл нь АНУ-ын Сэйвори Институтийн бэлчээрийн цогц менежментийн аргачлалыг орон нутгийн малчидтай хамтран нэвтрүүлэх замаар тэдний бэлчээрийн менежментийн талаарх мэдлэг, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавх, амьжиргааг дээшлүүлэх зорилготой гурван жилийн туршилтын төсөл юм. Энэхүү аргачлал нь экологийн тэнцвэртэй, тогтвортой байдал, бэлчээрийн ургамал нөхөн сэргэх хугацааг тодорхойлох, төлөвлөгөөтэй ашиглах талаарх мэдлэгийг малчдад олгох замаар тэдний бэлчээрийн ургамал сэргэх, чанаржих нөхцөлийг хангасан бэлчээрийн менежментийн шийдвэр гаргах чадавхыг бэхжүүлэхэд чиглэдэг. Түүнчлэн малчин эмэгтэйчүүдэд төрөл бүрийн, чанар аюулгүй байдлыг хангасан сүү/сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг явуулах арга зүйн болон техникийн дэмжлэг үзүүлснээр өрхийн орлогыг төрөлжүүлэх, нэмэгдүүлэх зорилготой.



ОНЦЛОХ АЖЛУУД

Төслийн нээлт, органик салбарын түншлэлийг бэхжүүлэх чиглэлээр

2023 оны 10 сард төслийн багийг байгуулж, “Органик хөдөө аж ахуйн түншлэл-2” төслийн нээлтийн үйл ажиллагааг Органик үйлдвэрлэгчдийн үндэсний VII чуулга уулзалтын үеэр зохион байгуулж нийт 120 орчим оролцогч талуудад танилцуулав. Төсөлд хамрагдах Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн 40 анхан шатны болон 1 дундын хоршоог шалгуурын дагуу сонгож, төслийн албан ёсны нээлтийг Дархан хотод зохион байгуулав. Төслийн хамтрагч 41 хоршоодоос гадна АДРА Герман, ХХААХҮЯ, Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн ЗДТГ, төрийн бус байгууллагууд, Ургамал газар тариалан эрдэм шинжилгээний хүрээлэнгийн судлаачид, хамтран ажиллагч байгууллагуудын нийт 126 төлөөлөгч оролцлоо. Нээлтийн үеэр Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн ЗДТГ болон АДРА Монгол ОУБ-ын хоорондын хамтын ажиллагааг улам бэхжүүлж, бүс нутгийн органик үйлдвэрлэл, нийлүүлэлтийн стратегийг уялдуулах зорилгоор хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурав.

АДРА Герман ОУБ-ын хөтөлбөрүүдийн зохицуулагч, хатагтай Виридиана К.Мартинез 11-р сард төслийн албан ёсны нээлтэд хүрэлцэн ирж оролцов. Тус айлчлалын үеэр төслийн үйл ажиллагаа, хамтрагч талуудтай танилцаж, мониторингийн аялал хийлээ. Үндэсний форум болон төслийн нээлтийн үеэр бүс нутагт органик хөдөө аж ахуйг хөгжүүлэх,

органик бүтээгдэхүүний тухай хуулийн төсөлд санал өгөх зорилгоор Үндэсний VII чуулганаас гаргасан зөвлөмж, төслийг хэрэгжүүлэх бүс нутгийн ажлын хэсэг байгуулах зэрэг үр дүнтэй хэлэлцүүлэг өрнүүлсэн юм.

Хоршооны гишүүдийн чадавхыг бэхжүүлэх чиглэлээр

Төслийн хүрээнд Дархан, Улаанбаатар хотод органик хөдөө аж ахуй, хамтын баталгаажуулалт, хоршоодын чадавх бэхжүүлэх, бизнес төлөвлөгөө боловсруулах, технологийн зэрэг сургалтуудыг орон нутагт болон Дархан, Улаанбаатар хотод зохион байгуулж, нийт 214 гишүүдийн мэдлэг, ур чадварыг бэхжүүлэх, чадавхжуулах ажлуудыг зохион байгуулсан байна.

Хоршооны гишүүдийн техникийн чадавхыг бэхжүүлэх чиглэлээр

Төслийн хүрээнд 5 хоршоог гар багаж, ХАА тоног төхөөрөмж болон хоршоодын нэмүү өртөг шингэсэн органик бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжин ажиллав. Мөн органик хүнсний үйлдвэрлэл, эрүүл ахуйн стандартыг хангах зорилгоор 3 хоршооны ажлын байрыг шинэчлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэв.

Тогтвортой орлогын эх үүсвэрийг бий болгох, хоршоодын гишүүдийг дэмжих, органик бүтээгдэхүүнийг сурталчлах зорилгоор Улаанбаатар хотод органик бүтээгдэхүүний хоёр дэлгүүр нээн ажиллуулж байна.





“ОРГАНИК ХӨДӨӨ АЖ АХУЙН ТҮНШЛЭЛ-2” ТӨСӨЛ (UROAg)

Эдийн засгийн хөгжил/ амьжиргаа

Санхүүжүүлэгч: ХБНГУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яам (75%), АДРА Герман (25%)

Төслийн төсөв: 1.6 сая евро (1.7 сая ам.доллар)

Төсөл хэрэгжих хугацаа: 2023 оны 10 дугаар сарын 1-нээс 2026 оны 12 дугаар сарын 31

Төсөл хэрэгжих аймаг: Сэлэнгэ аймгийн 11 сум болон Дархан-Уул аймгийн 2 сум

Төсөлтэй хамтрагч хоршоод: Сэлэнгэ аймгийн 11 сумын 30 хоршоо, Сэлэнгэ таван хайрхан дундын хоршоо, Дархан-Уул аймгийн 2 сумын 10 хоршоо

Хамтран ажиллах байгууллагууд: Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам, Сэлэнгэ аймгийн ЗДТГ, Дархан-Уул аймгийн ЗДТГ, Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын холбоо, Монгол ногоо төсөл, НҮБ-ийн ХХААБ, Дархан-Уул аймгийн Ургамал, газар тариалангийн хүрээлэн, Сэлэнгэ аймгийн Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг, баталгаажуулалтын байгууллагууд, органик үйлдвэрлэл эрхлэгчид

ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Бид 2018-2022 оны хооронд “Органик хөдөө аж ахуйн түншлэл” I төслийг хэрэгжүүлсэн ба уг төсөл нь дээрх төслийн үргэлжлэл бөгөөд төслийн хүрээнд Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн үйлдвэрлэл эрхлэгчид үйлдвэрлэл, маркетинг, баталгаажуулалт, борлуулалтын үр ашигтай нийлүүлэлт, борлуулалтын нэгдсэн сүлжээг хөгжүүлснээр органик хүнсний ногоо, зөгийн бал, органик нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн, сүү сүүн бүтээгдэхүүн болон бусад бүс нутгийн бүтээгдэхүүнийг зах зээлд хамтран үр ашигтай нийлүүлдэг болох, ингэснээр тэдний амьжиргааг тогтвортой нэмэгдүүлэхийг зорьж байна. Мөн органик үйлдвэрлэгчдэд ээлтэй орчинг бүрдүүлэх үүднээс органик үйлдвэрлэлийн салбарын хөгжлийн төлөөх бүс нутгийн болон үндэсний түвшний түншлэл, хамтын ажиллагааг дэмжин ажиллана.



МИРЗАБАЙН ТҮҮХ

ЭХНИЙ ЖИЛ БИ ӨӨРИЙН ЖИЖИГ ТАЛБАЙГААС 10 ШУУДАЙ БУЮУ 500 КГ ТӨМС ХУРААСАН. ДАРААГИЙН ЖИЛ ТАЛБАЙГАА ТӨМСГОН 1 ТОНН ТӨМС ХУРААВ. ЭНЭ НЬ МИНИЙ АМЬЖИРГААНД САЙНААР НӨЛӨӨЛЖ, ЭНЭ ОРЛОГООРОО БҮХИЙ Л ТӨЛБӨРӨӨ ТӨЛЖ БАЙНА. ҮНИЙ ЗЭРЭГЦЭЭ ГЭР БҮЛЭЭ АЮУЛГҮЙ ЭРҮҮЛЭХНСЭЭР ХАНГАХ БОЛОМЖТОЙ БОЛСОН.

АДРА-ДАА БАЯРЛАЛАА!

Мирзабай нь орон нутгийн онцлогт нийцсэн шинэлэг арга технологийг нэвтрүүлснээр байгаль орчин, цаг уурын хамгийн хэцүү нөхцөлд ч амжилттай хүнсний ногоо тариалах боломжтой гэдгийг баталж чадсан хүний нэг юм. Хэт хүйтэн өвөлтэй, халуун, хуурай зунтай газар тариалангийн бус уулархаг бүс нутагт хүнсний ногоо тариалах нь хүндрэл бэрхшээл ихтэй байдаг. Гэсэн хэдий ч орон нутгийн онцлогт нийцсэн шинэлэг арга техникийг сурснаар Мирзабай хүнсний ногоог үр дүнтэй тариалах боломжтой гэдгийг бусдадаа үлгэрлэн харуулсан. Тэрээр эрхэлсэн тодорхой ажилгүй, эхнэр, хоёр хүүхдийн хамт амьдардаг ба өрхийн амьжиргааны орлого олохын тулд мотоциклоор таксины үйлчилгээ үзүүлдэг байв. Төсөлд хамрагдахаасаа өмнө тэрээр эрс тэс хүйтэн цаг уур, үржил шим муутай хөрсөнд хүнсний ногоо тариалах боломжтой гэдэгт төдийлөн итгээгүй. Гэвч төслийн зохион байгуулсан газар тариалангийн сургалтаас олж авсан шинэ мэдлэг, арга технологи, мөн төслөөс олгосон баталгаат үрээр Мирзабай хашаагаа 10 төрлийн хүнсний ногоо тариалдаг хүнсний ногооны тариалангийн талбай болгон хувиргаж чадсан.

Тэрээр цаг уур, байгаль орчин, хөрсний үржил шим зэрэг олон бэрхшээлийг төслийн багийн тусламж, арга зүйн дэмжлэгтэйгээр амжилттай даван туулсан билээ.

Жилээс жилд Мирзабайгийн хичээл зүтгэл үр дүнгээ өгч тэрээр хашаанаасаа 1000 кг төмс, 500 кг өргөст хэмх, 50 кг сонгино болон бусад нарийн ногооны арвин ургац хурааж байна.

Жил жилийн арчилгааны үр дүнд талбайн хөрсний чанар нь сайжирч байгаад Мирзабай сэтгэл хангалуун байгаа төдийгүй тэрээр төслийн түншлэгч, үр шим хүртэгч байхын сацуу хөршүүдээ тариалан эрхлэхэд уриалж, тэднийг дэмжин, сурган ажиллаж байна.

ОНЦЛОХ АЖЛУУД



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ӨЛГИЙ, БУГАТ, САГСАЙ СУМЫН 845 ӨРХ ТАРИАЛАНГИЙН ТАЛБАЙТАЙ БОЛСНООР ТӨРӨЛ БҮРИЙН ЭРҮҮЛ НОГОО ТАРИАЛЖ, ХЭРЭГЛЭЖ ХЭВШИВ.



НИЙТ 45 УДААГИЙН ДАВТАН СУРГАГЧ БАГШИЙН СУРГАЛТААР 800 НОГООЧДЫГ ЧАДАВХЖУУЛАВ.



845 ГАЗАР ТАРИАЛАНГИЙН ГАРЫН АВЛАГА БОЛОВСРУУЛЖ, ХЭВЛЭЖ ТАРААВ.



ХООЛНЫ СУРГАЛТАД 655 ХҮНИЙГ ХАМРУУЛАВ.



НИЙТ 2,535 ГАЗАР ТАРИАЛАНГИЙН ГАР БАГАЖ ТАРААВ.



НИЙТ 11 ТӨРЛИЙН ХҮНСНИЙ НОГООНЫ ҮР ТАРААВ.



ОНЦЛОХ АЖЛУУД

- Баян-Өлгий аймгийн 3 сумын 845 өрхтэй хамтран ажиллаж, газар тариалангийн сургалтад хамрууллаа.
- Газар тариалангийн 45 сургагч багш бэлдэхийн зэрэгцээ үрслэг тариалах дулаалгатай жижиг мөлхөө хүлэмж болон ногоогоо хайрцаглан тарих 45 газар тариалангийн дадлагын талбай байгуулсан.
- Газар тариалангийн 8 бүлэг 34 сэдэв бүхий сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулж нийт 845 өрхдөө хэвлэж тараав.
- Зорилтот 3 сумдаа хоолны клуб ажиллуулж, хоолны сургалтад 655 хүнийг хамруулж, хоол хийх гарын авлагыг монгол, казах 2 хэл дээр боловсруулан хэвлэж нийт оролцогчдод тараасан.
- Нийт 845 оролцогч өрхүүддээ газар тариалангийн гар багаж болон 11 нэр төрлийн хүнсний ногооны үр тараасан.
- Олон амжилт, эерэг үр нөлөө, орон нутгийн иргэдийг цаашид үргэлжлүүлэн дэмжин ажиллах шинэлэг санал санаачилга, төлөвлөгөөтэйгөөр уг төслийг түншлэгч талуудын хамт амжилттай хэрэгжүүлж дуусгалаа.





Өрхийн Газар Тариаланг Дэмжих төсөл-2 (SAFER-2)

Хүнсний Аюулгүй байдал/
Эдийн засгийн хөгжил/ амьжиргаа

Санхүүжүүлэгч: Канадын Үр тарианы банк, АДРА Канад, АДРА БНХАУ-ХонгКонг, АДРА Нидерланд

Нийт төсөв: 488,853 Канад доллар

Хугацаа: 3 жил, 2020/04/01 - 2023/03/31

Зорилтот бүс нутаг: Баян-Өлгий аймгийн Өлгий, Бугат, Сагсай сум

Үр шим хүртэгсэд: 845 өрх, өрхийн 3887 гишүүд

ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Баян-Өлгий аймгийн тариалан эрхлэгчдийн хүнсний ногоо тариалах, тариалсан олон төрлийн хүнсний ногоогоор шим тэжээлтэй хоол, хүнс хийх мэдлэг, ур чадварыг бэхжүүлэх замаар тариалан эрхлэгч өрхүүдийн тоо, хүнсний ногооны үйлдвэрлэл, хэрэглээг нэмэгдүүлж, тэдний амьжиргаа мөн хүнсний болон хоол тэжээлийн аюулгүй байдлыг дэмжинэ.



ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ ГАЗРУУД

Зудын Яаралтай Хариу Арга
Хэмжээний төсөл (DEMBUZ)

Өрхийн Газар Тариаланг
Дэмжих төсөл-2 (SAFER-2)



Баян-Өлгий аймаг



Завхан аймаг



Бэлчээрийн Цогц Менежмент
төсөл (PLUS)



Халдварт Бус Өвчнөөс
Урьдчилан Сэргийлэх төсөл
(NCD)



**Органик Хөдөө Аж Ахуйн
Түншлэл-2 төсөл (UPOAg)**



Сэлэнгэ аймаг

Дархан-Уул аймаг

Улаанбаатар хот



**Нарийн болон Нарийвтар
Ноост Хонины Үүлдэр Угсааг
Сайжруулах төсөл (Fine Wool)**



**Дэм Дэмэндээ төсөл
(In-Their Shoes)**

2023 ОНЫ ОНЦЛОХ АЖЛУУД

3,887

БАЯН-ӨЛГИЙ
АЙМГИЙН 3,887
ӨРХ НОГООНЫ
ТАЛБАЙТАЙ
БОЛЖ, ТӨРӨЛ
БҮРИЙН
ХҮНСНИЙ НОГОО
ТАРИАЛДАГ
БОЛОВ.

378

УДАМШЛЫН ӨНДӨР АЧ
ХОЛБОГДОЛТОЙ 5000
ТУН ГҮН ХӨЛДӨӨСӨН
НАРИЙН НООСТ ХОНИНЫ
ҮР БОЛОН ХӨВРӨЛИЙГ
ИМПОРТОЛЖ, 378 ЭМ
ХОНИНД ХӨЛДӨӨСӨН
ҮРИЙН ЗОХИОМОЛ
ХЭЭЛТҮҮЛЭГ, ҮР ХӨВРӨЛ
ШИЛЖҮҮЛЭН СУУЛГАВ.

3,174

ЗАВХАН,
БАЯН-ӨЛГИЙ
АЙМГИЙН 3,174
ИРГЭНД ЗУДЫН
ҮЕИЙН ХАРИУ
АРГА ХЭМЖЭЭНИЙ
МӨНГӨН
ДЭМЖЛЭГ
ҮЗҮҮЛЭВ.

460

ЗАВХАН АЙМГИЙН
460 МАЛЧИН
БЭЛЧЭЭРИЙН
ЦОГЦ
МЕНЕЖМЕНТИЙН
АРГЫГ СУРЧ,
НЭВТРҮҮЛЭВ.

4,140

СЭЛЭНГЭ,
ДАРХАН-УУЛ
АЙМГИЙН 41
ХОРШООНЫ 4,140
ИРГЭН ОРГАНИК
ХӨДӨӨ АЖ
АХУЙН ТӨСӨЛД
ХАМРАГДАВ.

510

УЛААНБААТАР ХОТЫН
510 АМЬЖИРГААНЫ
БАТАЛГААЖИХ
ТҮВШНЭЭС ДООГУУР
ОРЛОГОТой ИРГЭД,
ӨРХ ТОЛГОЙЛСОН
ӨРХИЙН ХҮҮХДЭД
ХҮНСНИЙ БАГЦ,
ӨВЛИЙН ДУЛААН
ГУТАЛ ТАРААВ.

2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

АДРА Монгол ОУБ нь Монгол Улсын төрийн бодлого, нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн 5 тэргүүлэх чиглэл, тодруулбал хүнсний аюулгүй байдал, эдийн засгийн хөгжил/амьжиргаа, эрүүл мэнд, гамшгийн менежмент/гамшгийн үеийн хариу арга хэмжээ, боловсрол гэсэн салбарын хүрээнд төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлж байна. Тус байгууллага нь тусламж нэн шаардлагатай нийгмийн бүлэгт хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, мөн чадавх бэхжүүлэх аргыг баримталж, Монгол Улсад нийгмийн эрүүл мэнд, тогтвортой хөдөө аж ахуй, иргэдийн амьжиргаа, даван туулах, дасан зохицох чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлэхийг зорин ажиллав.

Бид хувь хүмүүс, орон нутгийн иргэд, шат шатны төр захиргааны, иргэний нийгмийн, олон улсын, эрдэм шинжилгээний зэрэг бүхий л түвшний, салбар салбарын байгууллагуудтай нягт хамтран, хамтдаа илүү үр дүнд хүрэхийг зорин бүхий л үйл ажиллагаагаа уялдуулан ажиллахыг эрмэлзэв. Ингээд Та бүхэнд 2023 онд хэрэгжүүлсэн төслүүдийн товч танилцуулгыг хүргэе.

Бид тогтвортой хөдөө аж ахуй, бэлчээрийн доройтлыг бууруулах чиглэлээр Завхан аймгийн Идэр суманд бэлчээрийн цогц менежментийн аргачлалыг турших, туршилтын төслийг хэрэгжүүлсэн. Төслийн үр дүнд бэлчээрийн чанарын үзүүлэлтүүд илт сайжирсан нь бидэнд уг төслийг өргөтгөх, шинэлэг байдлаар өргөжүүлэх, урам зориг өгсөн. Мөн малын чанарыг сайжруулснаар бэлчээрийн даацыг бууруулах, чанарыг сайжруулахад чиглэсэн Нарийн болон нарийвтар ноост хонины үүлдэр угсааг сайжруулах туршилтын төслийг хэрэгжүүлсэн. Энэхүү төсөл нь удамшлын өндөр ач холбогдолтой үр болон хөврөлөөр нарийн болон нарийвтар ноост хонины үүлдэр угсааг сайжруулах, тоо толгойг нэмэгдүүлэх зорилготой ба бид урт хугацааны тогтвортой үр нөлөөг хангахын тулд уг төслийг 6-8 жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл нэмэгдэж, үүнтэй холбоотой байгалийн гамшигт үзэгдлийн давтамж, цар хүрээ сүүлийн жилүүдэд үлэмж хэмжээгээр нэмэгдэж байгаа нь байгаль дэлхий, цаг агаараас хараат амьжиргаагаар малчин иргэдийн аж амьдралд ихээр нөлөөлж байна. Үүнтэй холбоотой бид сүүлийн 4 жилийн хугацаанд тасралтай Зудын нэн яаралтай хариу арга хэмжээ үзүүлэх төслийг хэрэгжүүлсэн ба 2023 онд бид Баян-Өлгий, Завхан аймгуудын тусламж нэн шаардлагатай малчин өрхүүдэд хүмүүнлэгийн тусламж үзүүлсэн.

Мөн тогтвортой хөдөө аж ахуй, хүртээмжтэй хөгжлийг дэмжих хүрээнд бид тогтвортой хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдлыг дэмжихэд чиглэсэн төслийг 2020-2023 оны хооронд Баян-Өлгий аймагт амжилттай хэрэгжүүлсэн. Уг төслийн үр дүнд 845 өрх орон нутгийн онцлогт тохирсон хөдөө аж ахуйн тогтвортой дадал, арга барилыг ашиглан хүнсний ногоо тариалж, тариалсан олон төрлийн эрүүл хүнсний ногоогоор шим тэжээлтэй хоол хүнс бэлтгэх, хэрэглэх эрүүл дадлыг төлөвшүүлж чадсан.

2023 оны 10-р сард ХБНГУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яам Органик хөдөө аж ахуйн түншлэл 2-р шатны төслийг баталсан ба тус төслийн зорилго нь бага талбайд тариалан эрхлэгчдийн органик үйлдвэрлэл, хамтын баталгаажуулалт, маркетинг, зах зээлд нэвтрэлтийг дэмжихээс гадна органик үйлдвэрлэлийн хөгжлийн төлөөх үр дүнтэй түншлэлийг талуудын оролцоотой бэхжүүлэх зорилготойгоор хэрэгжих юм.

Нийгэмд нэн хэрэгцээ шаардлагатай байгаа өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн мэдлэг олгох, эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх замаар халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх зорилготой төслийг эхлүүлсэн нь бидний энэ оны онцлох ажлуудын нэг байлаа. Төслийн хүрээнд 12-15 настай өсвөр үеийнхэн, эцэг эх, болон бусад талуудын хэрэгцээ, идэвхтэй оролцоо, санал санаачилгад үндэслэн эрүүл мэндийн мэдлэг, чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг хамтран боловсруулах, хэрэгжүүлэх замаар насан туршийн эрүүл амьдралын дадал, зан үйлийг өсвөр үеийнхэнд төлөвшүүлэхийг бид түншлэгч талуудын хамт зорин ажиллана.

Эцэст нь бид нийгмийн нэн шаардлагатай бүлэгт өвлийн дулаан гутал, хүнсний багц олгох “Дэм дэмэндээ” төслийг 2021 оноос уламжлал болгон хэрэгжүүлж байна. 2023 онд бид Налайх дүүрэг, ялангуяа Албан бус насан туршийн боловсролын төвийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд хүрч ажиллалаа.



АДРА ОУБ-ЫН ТАНИЛЦУУЛГА

Адвентист Хөгжил Туслалцааны Агентлаг (АДРА) нь 1956 онд Бурханы хайр, энэрэл нигүүлслийг үзүүлэх үүрэг бүхий Долоо дахь өдрийн Адвентист сүмийн үүсгэн байгуулсан, бие даасан хүмүүнлэгийн байгууллага юм.

АДРА ОУБ нь хөгжиж буй орнууд дахь нийгмийн шударга бус байдал, тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлж шийдвэрлэх, тусламж хэрэгтэй иргэдийн амьдралын чанарыг сайжруулахын төлөө ажилладаг. АДРА нь дэлхийн 130 гаруй улсад төлөөлөгчийн газартай бөгөөд тэдгээрийн нэг нь АДРА Монгол билээ.

АДРА Монгол ОУБ нь хүн бүрд байдаг эрхэм чанарыг хүлээн зөвшөөрч, хүний амьдралын чанарыг сайжруулахыг зорилгоо болгон, үндэс угсаа, улс төр, шашин шүтлэг харгалзахгүйгээр үйлчилдэг. Ялангуяа тусламж нэн шаардлагатай байгаа иргэд, тухайлбал, эмэгтэйчүүд, хүүхдүүд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн бүх бүлэгт хүрч үйлчилдэг.

АДРА Монгол ОУБ нь Монгол улсад 1994 оноос үйл ажиллагаагаа эхлүүлэн, өнгөрсөн 29 жилийн турш иргэд, орон нутаг, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж, Монголчуудын амьдралын чанарыг сайжруулахын төлөө хүнсний аюулгүй байдал, иргэдийн амьжиргаа/эдийн засгийн хөгжил, эрүүл мэнд, боловсрол, гамшгийн эрсдэлийг бууруулах таван бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд төсөл хөтөлбөрүүдээ хэрэгжүүлсээр ирсэн.

Тус байгууллага нь коммунист тогтолцоо нуран унасны дараа буюу 1994 онд МУ-ын Ерөнхий сайдын урилгаар үйл ажиллагаагаа эхлүүлсэн Монгол дахь анхны олон улсын төрийн бус байгууллага (ОУТББ) бөгөөд Азийн бүсэд хүмүүнлэг, хөгжлийн үйл ажиллагаа явуулдаг 17 суурин төлөөлөгчийн газрын нэг юм.

Өнөөдрийн байдлаар АДРА Монгол ОУБ нь боловсролын 58, гамшгийн менежментийн 25, эдийн засгийн хөгжил, амьжиргааг дээшлүүлэх 32, эрүүл мэндийн 37, хүнсний аюулгүй байдлын 41, нийт 193 төсөл хэрэгжүүлээд байна. 1994-2023 онд нийт зарцуулсан санхүүжилтийн хэмжээ ойролцоогоор 34,436,588 ам.долларт хүрсэн бөгөөд нэг жилд дунджаар 1,187,468 сая ам.доллар зарцуулжээ.

Эрхэм зорилго

Хүн төрөлхтнийг Бурханы хүслийн дагуу сайн сайхан амьдрахад туслах.

Уриа

Шударга ёс, Энэрэл, Хайр.

Алсын хараа

АДРА Монгол ОУБ нь мэргэшсэн, шинийг эрэлхийлэгч, тасралтгүй суралцагч, үр дүнтэй үйл ажиллагаа бүхий нэгдсэн, шударга, ил тод байдлыг хангасан олон улсын сүлжээ байгууллагад харьяалагддаг. АДРА нь орон зай, хил хязгаарын үл харгалзан нийгмийн эрсдэлт болон орхигдсон бүлгийн хүмүүсийг чадавхжуулан тэдний дуу хоолойг өргөн, тэдний амьдралд хэмжигдэхүйц, бодит, тогтвортой өөрчлөлтүүдийг авчрахын төлөө ажилладаг.

Мөн чанар

Адвентист Хөгжил Туслалцааны Агентлаг нь Бурханы хайр энэрлийг үзүүлдэг Долоо дахь өдрийн Адвентист сүмийн байгуулсан, даян дэлхийн хүмүүнлэгийн байгууллага юм.



ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ



ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ
БАЙДАЛ, ХӨДӨӨ АЖ АХУЙ



ЭРҮҮЛ МЭНД,
ШИМ ТЭЖЭЭЛ



ГАМШГИЙН МЕНЕЖМЕНТ/
ГАМШГИЙН ҮЕИЙН ХАРИУ
АРГА ХЭМЖЭЭ



ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ/
АМЬЖИРГАА



НӨЛӨӨЛӨЛ





ADRA

Бидний Зорилго

Хүн төрөлхтнийг Бурханы хүслийн дагуу амьдрахад тусална.

ХОЛБОО БАРИХ :



*ADRA Mongolia

Адвентист Хөгжил Туслалцааны Агентлаг Палаazzo Цамхаг #8-401 Токиогийн гудамж, 1-р хороо Баянзүрх дүүрэг Уланбаатар, Монгол Улс 15160

+976-11-450738 www.adra.org.mn

АГУУЛГА



2
СУУРИН ТӨЛӨӨЛӨГЧИЙН МЭНДЧИЛГЭЭ



8
2023 ОНЫ ОНЦЛОХ АЖЛУУД



16
ОРГАНИК ХӨДӨӨ АЖ АХУЙН ТҮНШЛЭЛ - 2 ТӨСӨЛ




22
НАРИЙН БОЛОН НАРИЙВТАР НООСТ ХОНИНЫ ҮҮЛДЭР УГСААГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ



28
ГАМШГИЙН БЭЛЭН БАЙДЛЫН СУРГАЛТ



4
ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ




10
ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ ГАЗРУУД



18
БЭЛЧЭЭРИЙН ЦОГЦ МЕНЕЖМЕНТ ТӨСӨЛ



24
ЗУДЫН ЯАРАЛТАЙ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨСӨЛ



30
САНХҮҮГИЙН ТАЙЛАН



6
АДРА ОУБ-ЫН ТАНИЛЦУУЛГА



12
ӨРХИЙН ГАЗАР ТАРИАЛАНГ ДЭМЖИХ ТӨСӨЛ-2



20
ХАЛДВАРТ БУС ӨВЧНӨӨС УРЬДИЛАН СЭРГИЙЛЭХ ТӨСӨЛ



26
ДЭМ ДЭМЭНДЭЭ ТӨСӨЛ



31
САНХҮҮЖҮҮЛЭГЧ БОЛОН ТҮНШЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУД

СУУРИН ТӨЛӨӨЛӨГЧИЙН МЭНДЧИЛГЭЭ

Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе!

Бид эргэцүүлэл, талархал дүүрэн нэг оныг үдэж, 2023 оны үйл ажиллагаагаа дүгнэж, Та бүхэнд өөрсдийн хийж гүйцэтгэсэн ажлуудаа энэхүү тайлангаар дамжуулан танилцуулахыг хүсэж байна. Өргөн уудам Монгол Улсын хэмжээнд бид даруухан үйл ажиллагаагаа явуулж, бурхны ивээлээр хүмүүсийн амьдралд эерэг нөлөө, сайн сайхан зүйлсийг бүтээхийн төлөө сэтгэл, зүтгэл гарган хичээн ажиллаа.

Дуулал 82:3-д зааснаар бид эмзэг, тусламж нэн шаардлагатай иргэдэд үйл ажиллагаа чиглүүлэн ажиллахыг зорьдог. 2023 онд энэ хүрээнд “Дэм дэмэндээ”, зудын үеийн хариу арга хэмжээний төслүүдийг хэрэгжүүлэв.

Бидний үйл ажиллагаа сорилт, бэрхшээлээс хол байсангүй. Зорилго, стратегийн дагуу санхүүжилтийг босгох, ажил амьдралын тэнцвэртэй байдлыг дэмжих зэргийг энэ хүрээнд дурдах боломжтой. Хүнд цаг мөчүүдэд сэтгэл зүтгэлээ гарган ажиллаж буй баг хамт олон, биднийг дэмжигч түншлэгч талууд, санхүүжүүлэгчид зэрэг нийт талуудын дэмжлэг, хамтын ажиллагааны үр дүнд бид үйл ажиллагаагаа үр дүнтэй, тасралтгүй, амжилттай явуулж чадлаа.


Ирэх жилийн үйл ажиллагаагаа бид эерэг, эрч хүчээр дүүрэн харж байна. 2024 онд бид стратеги бодлогын хүрээнд тодорхойлсон нэн чухал зорилго, зорилтуудыг хангахын тулд хүн төвтэй ажиллана. Бид мөн хүмүүсийг Бурханы хүслийн дагуу сайн сайхан амьдрахад дэмжиж ажиллахыг зорьж байна.

Санхүүжүүлэгч, дэмжигч байгууллагууд болон бусад нийт түншлэгч талууддаа гүнээ талархал илэрхийлье.

Та бүхний өгөөмөр сэтгэл, тусламж бидэнд тусламж, дэмжлэг нэн шаардлагатай хүмүүсийн амьдралд хүрч ажиллах боломжийг олгодог. Бид зөвхөн Монгол Улсын тухайд биш, бидний итгэж, хүсэж буй тэр дэлхийг бүтээх үйлсэд гар, сэтгэл нийлэн хамтарч ажиллаж байгаадаа баяртай байна.

Хүндэтгэсэн,

ВИНДЕЛЛ М.МАРАНАН



“Бид бурхны ивээлээр бидэнтэй хамтран ажиллаж буй хүмүүсийн амьдралд гарч буй эерэг өөрчлөлтийг хуваалцаж байгаадаа баяртай байна.”



ADRA



YEARS OF
JUSTICE, COMPASSION, LOVE

ЖИЛИЙН
ТАЙЛАН
2023

Монгол улс